



I–VI/2022

Тархаасан: 2022 оны 7 дугаар сарын 18



Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 140.2 (9.4%) тэрбум төгрөгөөр өслөө

Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2022 оны эхний хагас жилд 1636.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 140.2 (9.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 109.2 (8.4%) тэрбум төгрөгөөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлого 38.0 (72.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ЗУРАГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сараар, тэрбум төгрөгөөр




Нийгмийн даатгалын сангийн зарлага 2022 оны эхний хагас жилд 1626.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 90.7 (5.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 355.3 (31.2%) тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 6.8 (24.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 63 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар тус тус нэмэгдүүлэн Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 500000 (таван зуун мянган) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400000 (дөрвөн зуун мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон нь нийгмийн даатгалын сангийн зарлагын өсөлтөд нөлөө үзүүлж байна.

Улсын Их Хурлаас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан "Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль"-ийн дагуу 2022 оны 5 дугаар сард нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн 275681 даатгуулагчийн 8.3 тэрбум төгрөгийг буцаан олгосон байна.

ЗУРАГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, төрлөөр



Тэтгэврийн даатгалын сангаас 2022 оны эхний хагас жилийн байдлаар 471.5 мянган хүнд 1481.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 15.4 (3.4%) мянган хүнээр нэмэгдэж, олгосон тэтгэврийн хэмжээ 340.7 (29.9%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 2022 оны эхний хагас жилд 89.3 мянган хүнд 16.0 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 45.0 (2.0 дахин) мянган хүнээр нэмэгдэж, олгосон тэтгэмжийн хэмжээ 4.8 (42.4%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.



Эх үүсвэр:

Нийгмийн даатгалын ерөнхий газар,
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 10 дугаар сарын 17

Нийгмийн статистикийн
газрын дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Нийгмийн статистикийн газрын Нийгмийн
статистикийн хэлтсийн статистикч
Э.Ариунчимэг
Утас : (976-51)-263966

